

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: СЭА-2022/88-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Баасансүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: [baasansurens@audit.gov.mn](mailto:baasansurens@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БГАҮ</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ
<b>БҮТЭЗ</b>	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс
<b>ЗДНХ</b>	Засаг даргын нөөц хөрөнгө
<b>МУЕА</b>	Монгол Улсын Ерөнхий аудитор
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ТАХХ</b>	Төрийн алба хаасан хугацаа
<b>УСНББОУС</b>	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/88-НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АРДЫН ДУУ  
БҮЖГИЙН СЭЛЭНГИЙН ДОЛГИО ЧУУЛГЫН  
ДАРГА Д.УРАНБИЛЭГ ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>217,581,249.00</b>	<b>231,064,299.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>217,581,249.00</b>	<b>231,064,299.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>217,581,249.00</b>	<b>231,064,299.00</b>
35410	Бичиг хэргийн материал	-	153,300.00
35420	Аж ахуйн материал	-	4,178,080.00
35440	Түлш, шатах тослох материал	-	130,000.00
35470	Бусад хангамжийн материал	217,581,249.00	226,602,919.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,255,011,385.26</b>	<b>1,183,439,566.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,255,011,385.26</b>	<b>1,183,439,566.79</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,206,669,385.26</b>	<b>1,132,897,566.79</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,055,715,659.47	1,055,715,659.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(54,515,455.44)	(98,503,607.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,840,000.00	81,840,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(70,705,266.84)	(78,889,266.84)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	-	2,224,850.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(7,812.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,540,641.50	57,044,195.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,248,994.25)	(35,430,645.70)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,442,401.42	6,442,401.42
39210	Хуримтлагдсан элэгдэл	(383,476.20)	(690,257.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	231,604,358.00	227,110,131.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(67,620,482.40)	(83,958,080.52)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>48,342,000.00</b>	<b>50,542,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	48,342,000.00	50,542,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,472,592,634.26</b>	<b>1,414,503,865.79</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>259,690.58</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b>259,690.58</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	<b>259,690.58</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	259,690.58
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,472,592,634.26</b>	<b>1,414,244,175.21</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,472,592,634.26</b>	<b>1,414,244,175.21</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	726,026,057.50	726,026,057.50
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(368,996,099.35)</b>	<b>(427,344,558.40)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(330,911,002.59)	(368,996,099.35)
51220	Тайлант үеийн үр дүн	(38,085,096.76)	(58,348,459.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,115,562,676.11	1,115,562,676.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,472,592,634.26</b>	<b>1,414,503,865.79</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>872,569,190.00</b>	<b>869,277,458.95</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,640,900.00</b>	<b>14,484,573.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>46,640,900.00</b>	<b>14,484,573.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	44,919,000.00	10,140,823.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,721,900.00	4,343,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>825,928,290.00</b>	<b>854,792,885.95</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,490,700.00</b>	<b>16,094,160.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018,000.00	10,980,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,472,700.00	5,114,160.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>818,437,590.00</b>	<b>838,698,725.95</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	818,437,590.00	838,698,725.95
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>909,211,607.78</b>	<b>927,625,918.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>909,211,607.78</b>	<b>927,625,918.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>866,147,007.78</b>	<b>923,852,918.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>526,151,577.57</b>	<b>570,219,554.04</b>
210101	Үндсэн цалин	478,492,369.27	447,854,884.55
210102	Нэмэгдэл	47,659,208.30	122,364,669.49
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,382,625.84</b>	<b>74,889,544.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,902,123.60	52,649,857.30
210202	Тэтгэмжийн даатгал	5,254,638.29	5,860,570.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,486,236.02	4,644,776.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,067,148.09	1,066,758.29
210205	Эрүүл мэндийн даатгал	10,672,479.84	10,667,582.27
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>164,157,327.59</b>	<b>168,723,052.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,960,217.70	4,408,030.79
210302	Түлш, халаалт	153,626,402.89	159,332,689.70
210303	Цэвэр, бохир ус	5,570,707.00	4,982,332.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,908,545.00</b>	<b>6,948,526.00</b>
210401	Бичиг хэрэг	2,153,900.00	664,000.00
210402	Тээвэр, шатахуун	915,200.00	450,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,701,100.00	1,489,986.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.00	195,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,413,000.00	4,148,640.00
210408	Бараа материал акталсны зардал	5,569,345.00	-

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	<b>56,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	56,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,124,200.00</b>	<b>1,755,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	-
210604	Урсгал засвар	4,824,200.00	1,755,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>770,900.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	770,900.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,965,300.00</b>	<b>16,973,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,731,500.00	16,705,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	68,800.00	155,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	79,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	95,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>80,686,531.78</b>	<b>84,287,641.47</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,018,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,668,531.78	84,287,641.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,064,600.00</b>	<b>3,773,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,064,600.00</b>	<b>3,773,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,064,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,773,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(36,642,417.78)</b>	<b>(58,348,459.05)</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,442,678.98</b>	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,442,678.98	-
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(38,085,096.76)</b>	<b>(58,348,459.05)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>825,928,290.00</b>	<b>854,792,885.95</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>825,928,290.00</b>	<b>854,792,885.95</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,490,700.00</b>	<b>16,094,160.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018,000.00	10,980,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,472,700.00	5,114,160.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>818,437,590.00</b>	<b>838,698,725.95</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	818,437,590.00	838,698,725.95
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>820,002,390.00</b>	<b>852,217,885.95</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>820,002,390.00</b>	<b>852,217,885.95</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>776,937,790.00</b>	<b>848,444,885.95</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>521,452,236.57</b>	<b>569,959,863.46</b>
210101	Үндсэн цалин	454,336,270.17	447,595,193.97
210102	Нэмэгдэл	67,115,966.40	122,364,669.49
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,382,625.84</b>	<b>74,889,544.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	49,902,123.60	52,649,857.30
210202	Тэтгэмжийн даатгал	5,254,638.29	5,860,570.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,486,236.02	4,644,776.07
210204	Ажилгүйдлийн даатгал	1,067,148.09	1,066,758.29
210205	Эрүүл мэндийн даатгал	10,672,479.84	10,667,582.27
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>164,157,327.59</b>	<b>168,723,052.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,960,217.70	4,408,030.79
210302	Түлш, халаалт	153,626,402.89	159,332,689.70
210303	Цэвэр, бохир ус	5,570,707.00	4,982,332.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,339,200.00</b>	<b>7,171,076.00</b>
210401	Бичиг хэрэг	2,153,900.00	817,300.00
210402	Тээвэр, шатахуун	915,200.00	580,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,701,100.00	1,489,986.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	156,000.00	195,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,413,000.00	4,087,890.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>102,750.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	102,750.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,852,200.00</b>	<b>1,755,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	-
210604	Урсгал засвар	5,552,200.00	1,755,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>770,900.00</b>	<b>-</b>

210702	Дотоод албан томилолт	770,900.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,965,300.00</b>	<b>25,843,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,731,500.00	25,576,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	95,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	68,800.00	155,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,000.00	79,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,018,000.00</b>	<b>-</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,018,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,064,600.00</b>	<b>3,773,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,064,600.00</b>	<b>3,773,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,064,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,773,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>5,925,900.00</b>	<b>2,575,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>5,925,900.00</b>	<b>2,575,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,925,900.00</b>	<b>2,575,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,925,900.00</b>	<b>2,575,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,925,900.00	2,575,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(5,925,900.00)</b>	<b>(2,575,000.00)</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(330,911,002.59)	1,510,677,731.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(330,911,002.59)	1,510,677,731.02
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(38,085,096.76)	(38,085,096.76)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(368,996,099.35)	1,472,592,634.26
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(368,996,099.35)	1,472,592,634.26
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(368,996,099.35)	1,472,592,634.26
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(58,348,459.05)	(58,348,459.05)
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	726,026,057.50	1,115,562,676.11	(427,344,558.40)	1,414,244,175.21

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				217143892
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	844,432,800.00	838,698,725.95	5,734,074.05	99.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	844,432,800.00	838,698,725.95	5,734,074.05	99.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,816,100.00	837,082,025.95	5,734,074.05	99.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	573,106,000.00	569,959,863.46	3,146,136.54	99.45
210101	Үндсэн цалин	462,574,800.00	447,595,193.97	14,979,606.03	96.76
210102	Нэмэгдэл	110,531,200.00	122,364,669.49	(11,833,469.49)	110.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,369,300.00	74,889,544.00	2,479,756.00	96.79
210201	Тэтгэврийн даатгал	54,445,100.00	52,649,857.30	1,795,242.70	96.70
210202	Тэтгэмжийн даатгал	5,731,100.00	5,860,570.07	(129,470.07)	102.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,584,800.00	4,644,776.07	(59,976.07)	101.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,146,200.00	1,066,758.29	79,441.71	93.07
210205	Эрүүл мэндийн даатгал	11,462,100.00	10,667,582.27	794,517.73	93.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168,221,900.00	168,199,192.49	22,707.51	99.99
210301	Гэрэл, цахилгаан	4,444,300.00	4,408,030.79	36,269.21	99.18
210302	Түлш, халаалт	156,118,500.00	158,808,829.70	(2,690,329.70)	101.72
210303	Цэвэр, бохир ус	7,659,100.00	4,982,332.00	2,676,768.00	65.05
2104	Хангамж, бараа материалын зардал	6,869,600.00	6,867,076.00	2,524.00	99.96
210401	Бичиг хэрэг	788,200.00	817,300.00	(29,100.00)	103.69
210402	Тээвэр, шатахуун	612,000.00	580,800.00	31,200.00	94.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,692,000.00	1,489,986.00	202,014.00	88.06
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	195,100.00	304,900.00	39.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,277,400.00	3,783,890.00	(506,490.00)	115.45
2105	Нормативт зардал	102,800.00	102,750.00	50.00	99.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	102,800.00	102,750.00	50.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал				
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,146,500.00	17,063,600.00	82,900.00	99.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,800,000.00	16,796,300.00	3,700.00	99.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	79,200.00		79,200.00	
210803	Даатгалын үйлчилгээ	155,000.00	155,000.00		100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,300.00	79,300.00		100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00		100.00

**Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,616,700.00	1,616,700.00		100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,616,700.00	1,616,700.00		100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,616,700.00	1,616,700.00		100.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>				
	Дотоод эх үүсвэрээр				
223001	Бусад хөрөнгө				
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	844,432,800.00	838,698,725.95	5,734,074.05	99.32
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	844,432,800.00	838,698,725.95	5,734,074.05	99.32
132001	Орон нутгийн төсвөөс	844,432,800.00	838,698,725.95	5,734,074.05	99.32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
1	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
3	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.00
5	АЖИЛЛАГСДЫН ТОО				
6	Удирдах ажилтан	3.00	3.00		100.00
7	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00		100.00
8	Үйлчлэх ажилтан	14.00	14.00		100.00
24	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>				
30	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	43.00	43.00		100.00
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.00	14.00		100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,990,700.00	16,094,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,990,700.00	16,094,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,990,700.00	13,937,860.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	555,900.00	523,860.00
210302	Түлш, халаалт	555,900.00	523,860.00
2104	Хангамж, бараа материалын зардал		304,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		304,000.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,645,900.00	2,130,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,645,900.00	375,000.00
210604	Урсгал засвар		1,755,000.00
2107	Томилолт, зочны зардал	770,900.00	
210702	Дотоод албан томилолт	770,900.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,980,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,980,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,018,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,018,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,156,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,156,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,156,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
222001	Тоног төхөөрөмж		
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,497,000.00	16,094,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,497,000.00	16,094,160.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,018,000.00	10,980,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	479,000.00	5,114,160.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### 3.Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ардын дуу бүжгийн Сэлэнгийн долгио чуулга / цаашид Сэлэнгийн Долгио чуулга гэх /-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим системд шивэгдээгүй, нотлох дэмжих боломжгүй бараа материалын худалдан авалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сэлэнгийн долгио чуулга нь “Ардын болон язгуур урлагийн мөн чанарыг хадгалан хөгжүүлж, орон нутгийн онцлогт тулгуурлан ардын дуу бүжгээр урлагийн бүтээл үйлдвэрлэж, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжинэ.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Сэлэнгийн долгио чуулгын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл урлагийн олон талт үзвэр үйлчилгээгээр ард иргэдийг соён гэгээрүүлэх,
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх,
- Чанартай, хүртээмжтэй уран бүтээл туурвих,
- Хүний нөөцийн удирдлагаар хангах.

Тайлант хугацаанд сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Сэлэнгийн долгио чуулгын мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгийн долгио чуулгын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 818,437.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,276.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 9,207.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сэлэнгийн Долгио чуулгын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,088.8 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	217,581.2	231,064.3	13,483.1
Үндсэн хөрөнгө	1,255,011.4	1,183,439.5	(71,571.9)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,472,592.6</b>	<b>1,414,503.8</b>	<b>(58,088.8)</b>
Өр төлбөр		259.6	259.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>1,472,592.6</b>	1,414,244.2	(58,348.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,472,592.6</b>	<b>1,414,503.8</b>	<b>(58,088.8)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 231,064.3 мянган төгрөг болж 13,483.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн санхүүжилтээр нийт 31,037.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 4,343.7 мянган төгрөг /*Наадмын дэнж, Орхон-Сэлэнгэ бүжгийн дээл, өмд, хантаазыг үнэлж бүртгэсэн.*/ -ийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, нийт 21,897.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /*анхны өртгөөр*/ 1,480,919.2 мянган төгрөг болж өмнөх оноос 7,565.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн санхүүжилтээр 2,575.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан болон аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 708 дугаар албан бичгийн дагуу элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23 нэр төрлийн 20,281.6 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 10,140.8 мянган төгрөгөөр дахин үнэлж, орлогод бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,414,244.2 мянган төгрөг болж 58,348.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого нь өмнөх оноос 11,292.9 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан нь орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого 28,658.4 мянган төгрөгөөр буурсан бол үнэ төлбөргүйгээр хүлээн авсан орлого 14,484.5 мянган төгрөгөөр өссөн нөлөөллөөс голлон шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал нь өмнөх оноос 78,130.4 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил / Төрийн үйлчилгээний албан хаагчдад ТАХХ-ын нэмэгдэл олгож эхэлсэнтэй холбоотой./ -ын зардал 44,068.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 3,506.9 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардал 4,565.7 мянган төгрөгөөр, БГАҮ-ний төлбөр хураамж / уран бүтээл / -ийн зардал 12,838.6 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардал 4,619.1 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сэлэнгийн долгио чуулга нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 988,427.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 154,634.9 мянган төгрөг өөр бууруулж, 833,792.8 мянган төгрөгөөр баталсан бол 2021 оны 12 дугаар сард батлагдсан төсөвт өөрчлөлт оруулан 10,640.0 мянган төгрөг / 5 дугаар сард 15, 9 дүгээр сард 15 хоног буюу 1 сараар халаалттай байх хугацааг нэмсэнтэй холбоотой./ -өөр нэмэгдүүлж **844,432.8 мянган төгрөгөөр** эцэслэн баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 844,432.8 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 838,698.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **838,698.7** мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 3,146.1 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2,479.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 2.5 мянган төгрөгөөр, БГАҮ-ний төлбөр хураамжийн зардлыг 82.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус чуулгын нэмэлт санхүүжилтийн 100130035404 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,114.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2021 оны А/403 дугаар захирамжаар ЗДНХ-өөс “Ургацын баяр”-т зориулсан уран бүтээлийн зардалд 10,980.0 мянган төгрөг зэрэг нийт 16,094.1 мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Үүнээс байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 523.8 мянган төгрөг, БҮТЭЗ худалдан авах зардалд 304.0 мянган төгрөг, багаж, техник, хэрэгсэл худалдан авахад 375.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,755.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж буюу уран бүтээлийн зардалд 10,980.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 2,156.3 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

3.7.1. Тайлант онд Дархан-Уул аймгийн Залуучууд театрт хөгжимчний албан тушаал хашиж буй О.Золбаярыг хөгжмийн зохиолчийн албан тушаалд үндсэн ажилтнаар томилон ажиллуулж 787.1 мянган төгрөгийн цалин, нэмэгдэл олгосон байна. Цаашид шаардлагатай мэргэжлийн албан хаагчийг түр хугацаагаар ажиллуулахдаа “ Ажил гүйцэтгүүлэх гэрээ ” байгуулж, үндсэн цалингаас бус гэрээтийн цалингаас цалинжуулах нь зүйтэй юм.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сэлэнгийн долгио чуулга нь тайлант онд шилэн дансны цахим хуудаг мэдээлбэл зохих 149 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сэлэнгийн долгио чуулгын тайлант оны үйл ажиллагаанд **844,432.8** мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр **838,698.7** мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,948.3 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,865.9 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 674.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлснээс акт, албан шаардлагыг бүрэн биелүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,948.3	2	1,948.3	-	-	100.0
Албан шаардлага	1	4,865.9	1	4,865.9	-	-	100.0
Зөвлөмж	2	674.3	1	674.3	1	-	-
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>7,488.5</b>	<b>4</b>	<b>7,488.5</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>80.0</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **5,509.3** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 287.8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,221.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгөв.

### 4.1 Төлбөрийн акт

1. Төрийн алба хаасан хугацааг зөрүүтэй тооцож, жижүүр Н.Даваанямд 287.8 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.” “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно: 16-20 жил (181-240 сар)-д 15 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Илүү олгосон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

#### **4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны болон төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Тайлант онд 5,221.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг тус тус зөрчсөн тул төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх.

##### **2. Зардлын данстай холбоотой асуудал**

**2.1 Илрүүлэлт:** Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягаар хөтлөөгүй, спидометрийн заалт бичигдээгүй, шатахуун зарцуулсан албан хаагчийн гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Дээрх зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.” гэсэн заалт

болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн тул цаашид батлагдсан жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж, холбогдох үзүүлэлтүүдийг бүрэн гүйцэт бүртгэх, шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгийн долгио чуулга	3	5,509.3	-	-	1	287.8	-	-	2	5,221.5